



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/211

Чингис хот

Тусгай зөвшөөрөлд  
өөрчлөлт оруулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.4, 30 дугаар зүйлийн 30.1.6, 30.1.16, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны ажилчдын хүүхдэд зориулсан цэцэрлэгийг Хэрлэн сумын VII цэцэрлэгийн харьяа салбар бүлэг болгон зохион байгуулсантай холбогдуулан сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулсугай.

2. Сургалтын байгууллагын бүлгийн тоо "4" байсныг өөрчилж "5" болгосугай.

3. Нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийг тус цэцэрлэгийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд тэмдэглэж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010554